



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 08 сарын 10 өдөр

Дугаар А/463

Эрдэнэт

**Хөрөнгө гаргах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 "а", 29.2, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Барилгын салбар үүсч хөгжсөний 91 жилийн ойг тохиолдуулан аймгийн хэмжээнд барилгын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд "Их барилга-91" сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.
2. "Их барилга-91" сэдэвт хэлэлцүүлгийг өндөр түвшинд зохион байгуулж, үр дүнг танилцуулахыг Хотын захирагчийн алба /н.Түмэнжаргал/-нд даалгасугай.
3. Дээрх зардалд шаардагдах 2.000.000 /Хоёр сая/ төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гаргахыг Санхүү төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



С.БАТЖАРГАЛ

Аймгийн Засаг даргын 2017 оны 08 дугаар  
сарын 08 ны өдрийн 45 дугаар  
захирамжийн хавсралт

ИХ БАРИЛГА-91 ХЭЛЭЛЦҮҮЛЭГИЙН ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын төрөл	Нэгжийн үнэ	Дүн
1	Хавтас	800	80,000
2	Дэвтэр	3000	300,000
3	Бал	700	70,000
4	Үдийн цай, хоол	15500	1,550,000
Нийт			2,000,000

-ОоО-